

## ШАРГА СУМД 2017 ОНЫ 3 ДУГААР САРД БОЛСОН

### ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

2017.03.28

Баянгол

#### БАГИЙН ЗАСАГ ДАРГА НАРТ БАТЛАМЖИЙГ ГАРДУУЛЛАА

Монгол улсын хууль тогтоомж, төрийн бодлого шийдвэрийг сурталчлан таниулах, хууль тогтоомжийн хэрэгжилт, баримт бичгийн стандартыг хангуулах, мэдээ тайлангийн чанарыг дээшлүүлэх зорилгоор 4 багийн Засаг дарга, Иргэдийн Нийтийн хурлын дарга нарт сургалтыг 3 сарын 06-ны өдөр зохион байгуулж 12 байцаагч мэргэжилтэн чиглэл чиглэлийнхээ хууль тогтоомжийг танилцууллаа. Мөн хугацаатай тайлан мэдээ, судалгаа, баримтлах эрх зүйн акт, журам зааврыг багтаасан гарын авлагыг бэлтгэж гардууллаа. Сургалтыг Засаг дарга М.Тунгалагтамир нээж шинээр сонгогдсон багийн Засаг дарга нарт томилсон захирамжийг, сургалтын төгсгөлд батламжийг гардуулж ажлын амжилт хүслээ.



#### ХУУЛЬ СУРТАЛЧЛАХ АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Эрх зүйн сургалт сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Монгол цэргийн өдрийг угтаж цэргийн үүрэгтний эрх зүйн байдлын тухай хуулийг сурталчлах ажлын хүрээнд Марш тактикийн тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд 6 хүний бүрэлдэхүүнтэй 7 баг оролцож 1-3 байрыг эзлүүлэн шагнаж урамшууллаа. Тэмцээний шагналд сургалт сурталчилгааны зардлаас 60000 төгрөгийг зарцууллаа.


**Боловсролын талаар:**

Дуулах өв -2017, Уран жиргээ-2017 улсын уралдааны 1-р шатыг сургууль дээрээ зохион байгуулж, шалгарсан 3а ангийн Ш.Анхчимэг, 7а ангийн сурагч Г.Тэргэл, 8а ангийн сурагч С.Даваахишиг, “Уран жиргээ”-д 5а ангийн сурагч Б.Болортуяа, 7а ангийн сурагч З.Энхжин, 11а ангийн сурагч М.Хонгорзул нар 2-р шатанд оролцлоо. Дуулах өв 2-р шатнаас 3а ангийн сурагч Ш.Анхчимэг 3-р байр эзлэв.



Сургалтын чанарыг ахиулах “Дэд” хөтөлбөр, “Багшийн хөгжил” хөтөлбөр, “Оюунлаг Алтай” хөтөлбөрийн төслийг сургуулийн нийт эцэг эхчүүд, багш, ажилчид, төрийн албан байгуулагуудаар хэлэлцүүлэн, гарсан саналыг БСУГ-т хүргүүлээ.

3 сарын 14-наас 4 сарын 6-ны хооронд “Цахим гадуурхал цаашаа” үйл ажиллагааны хүрээнд “Цахим орчин дах гадуурхал” сэдэвт гар зураг, эссе бичлэгийн уралдаан зарлан, шилдэг бүтээлүүдийг БСУГ-т хүргүүлнэ.



### **Эрүүл мэндийн талаар:**

2017 оны 03-р сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд : Нийт жирэмсэн 14, шинээр хяналтанд авсан 3 ,жирэмсний эрт хяналтын хувь 92,8%, хөхний эрт илрүүлэгт хамрагдсан 20 \25,9%\, умайн хүзүүний үзлэгт хамрагдсан 15\17,2%\ байна.

Эмийн татан авалт тендер бусаар 2,6 сая, тендерээр 2,7 сая төгрөгний эм бараа татан авсан. Энгийн эмийн жороор 54 хүн, хөнгөлөлттэй эмийн жороор 129 хүн үйлчлүүлж 1.3 сая төгрөгний эмийн хөнгөлөлт олгосон байна.

Нийт үзлэг 595 ,гэрийн хяналт 230, идэвхтэй хяналт 59, урьдчилан сэргийлэх үзлэгт 42, гэрийн дуудлага 82, элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт 13 \3,1%\, артерийн гипертенз, чихрийн шижингийн эрт илрүүлэгт 27 \6,1%\ -тай байна. Түргэн тусламжийн дуудлага 57, үүнээс алсын дуудлага 22% осол гэмтлийн дуудлага 1, нийт нас баралт 2, хорт хавдрын нас баралт 2 байна. Эмнэлэгт хэвтсэн 61, эмнэлгээс гарсан 61 хүн байна. Шээсний ерөнхий шинжилгээнд 15, цусны ерөнхий шинжилгээнд 16, цэрний сорьц тээвэрлэлт 3, цагаан хорхой, серологи 2, элэгний В вирус 1 тус тус хийлээ. 3-р сард нийт хатгалт 522, үүнээс дундаж хатгалт 113.6, булчин тариа хийлгэсэн 2017 онд тэмбүү, ХДХВ –ийн шинжилгээнд 3 хамрууллаа. Хам шинжийн оношилгоонд 14 хүн хамруулж эмчилгээнд 5 хүн, НЭ – лүү 5 хүн шинжилгээнд илгээлээ. 2016 оны 3 сарын байдлаар халдварт өвчний тохиолдол 1, үүнээс тэмбүү өвчтэй 1 хүнийг илрүүлэн хяналтанд аван эмчилж байна.

3-р сард 30 эрчүүдэд “Бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлье” сургалтыг явууллаа. Мөн уралдаан тэмцээнд 560000 төгрөгийг зарцуулсан байна.

### **СУМЫН ИТХ-ЫН ИҮ ХУРАЛДААН БОЛЛОО**

Сумын ИТХ-ын 4-р хуралдаан энэ сарын 16-ны өдөр болж Сумын Засаг даргын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, сумын 2017 оны үндсэн чиглэлийг баталлаа.

**Мэдээ бэлтгэсэн: Д.Ончимэг**

